

ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

Хэрсүү байх

Мормон 1:2, 15-ыг уншаад, “хэрсүү” гэдэг үгийг тэмдэглэх талаар бодож үз. (Хэрсүү гэдэг нь хүндэтгэл бишрэлтэй, нухацтай, бодолтой гэсэн утгыг илэрхийлж болно гэдгийг та нар судартаа тэмдэглэ.)

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ерөнхийлөгч Бойд К.Пакэрын (1924–2015) хэлсэн дараах мэдэгдлийг унш.



Бид Сүмд сүсэг бишрэлтэй болон сүсэг бишрэлгүй зан байдлыг хардаг. Эдгээрийн олонх нь магтууштай боловч үнэндээ бид байвал зохих бишрэл хүндэтгэлтэй байдлаас аажим аажмаар холдсоор байна. Бидэнд энэ талаар нухацтай бодох шалтгаан бий.

“Бишрэл хүндэтгэлгүй байдал нь оюун санааны хийгээд сүнсний аль алиных нь илчлэлтийн нарийн, эмзэг сувгуудыг хаах гэсэн дайсны зорилготой нийцдэг билээ. (Boyd K. Packer, “Reverence Invites Revelation,” *Ensign*, Nov. 1991, 22)

- Хүндэтгэл бишрэлтэй, нухацтай хандах ёстой атал заримдаа эсрэгээрээ байдаг ямар зүйл байдаг вэ?
- Аврагч хэрсүү (хүндэтгэл бишрэлтэй, нухацтай, бодолтой) байхыг ямар арга замаар үлгэрлэсэн бэ?

ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

Ажиглан ойлгохдоо түргэн

Мормон 1:2-ыг уншаад, “ажиглан ойлгохдоо түргэн” гэдэг үгийг тэмдэглэх талаар бодож үз.

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Беднарын хэлсэн дараах үгсийг унш.



Ажиглан ойлгохдоо түргэн байх үед бид яг цагийг нь олж харах эсвэл танин дуулгавартай байх чадвартай байдаг. Эдгээр олж харах, дуулгавартай байх гэсэн үндсэн хоёр элемент нь ажиглан ойлгоход түргэн байхад маш чухал. Бошиглогч Мормон нь үйлдлээрээ энэ бэлгийн гайхалтай жишээ болсон хүн юм. (David A. Bednar, “Quick to Observe,” *Ensign*, Dec. 2006, 32)

- Та нар ямар сургаалыг ажиглан ойлгохдоо түргэн байж, дуулгавартай дагахад тустай гэж үзсэн бэ? Яагаад?
- Хожим нас явахаараа Их Эзэнд дуулгавартай байна гэж боддог найздаа та нар ямар зөвлөгөө өгөх вэ?
- Есүс Христ ажиглан ойлгохдоо түргэн байхыг ямар арга замаар үлгэрлэсэн бэ?